



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/147НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Р.Аюуш Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5. Залруулсан алдаа.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.БАЯРТАЙХАНЦЭЦЭГ
ТАНАА

2026.02.24 № УВА-2026/147/НА-САН-ТМЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050234

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>172,775,621.30</u>	<u>143,840,578.99</u>
33	АВЛАГА	160,764.80	577,355.49
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	160,764.80	577,355.49
35	БАРАА МАТЕРИАЛ	172,614,856.50	143,263,223.50
354	Хангамжийн материал	160,824,313.00	117,670,013.00
35410	Бичиг хэргийн материал	15,188,733.00	14,233,933.00
35420	Аж ахуйн материал	49,696,080.00	49,696,080.00
35470	Бусад хангамжийн материал	95,939,500.00	53,740,000.00
35600	Мал амьтад	11,790,543.50	25,593,210.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,773,286,202.10</u>	<u>3,123,044,957.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,773,286,202.10	3,123,044,957.48
392	Биет хөрөнгө	2,695,857,202.10	3,038,857,624.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,721,837,388.39	3,069,325,569.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(454,470,936.77)	(474,223,952.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	490,016,500.00	413,126,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(248,902,903.07)	(224,480,326.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	346,698,875.40	396,431,256.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	(271,244,733.72)	(302,137,707.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	159,893,388.00	213,356,138.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(58,170,376.13)	(62,739,853.81)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,200,000.00	10,200,000.00
393	Биет бус хөрөнгө	77,429,000.00	84,187,333.30
39301	Программ хангамж	1,710,000.00	4,710,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,335,000.00)	(1,576,666.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	82,004,000.00	86,004,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(4,950,000.00)	(4,950,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,946,061,823.40</u>	<u>3,266,885,536.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,858,200.00</u>	<u>10,738,275.28</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,858,200.00	10,738,275.28
413	Өглөг	1,858,200.00	10,738,275.28
4136	Бусад өглөг	1,858,200.00	10,738,275.28
41361	Байгууллагад төлөх өглөг	1,858,200.00	10,738,275.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,944,203,623.40</u>	<u>3,256,147,261.19</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,944,203,623.40	3,256,147,261.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	430,458,213.17	430,458,213.17
51101	Өмч: - төрийн	430,458,213.17	430,458,213.17
512	Хуримтлагдсан үр дүн	2,383,178,664.86	2,742,659,596.86
51210	Өмнөх үеийн үр дүн	2,383,178,664.86	2,430,691,209.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	311,968,387.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,566,745.37	83,029,451.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,946,061,823.40</u>	<u>3,266,885,536.47</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөг/	
		1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,667,380,983.00	1,669,180,022.50
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	494,603,712.00	1,669,180,022.50
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	494,603,712.00	607,283,450.50
120004	1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	494,603,712.00	25,180,549.00
1200041	1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,697,989.00	12,468,349.00
1200042	1.1.1.04.1.04.02 Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	12,712,200.00
1200045	1.1.1.04.1.04.04 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	481,905,723.00	-
120017	1.1.1.04.1.13 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	502,769,691.00
120018	1.1.1.04.1.14 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	79,333,210.50
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,061,896,572.00
1221	1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	1,061,896,572.00
12211	1.1.1.04.3.01.01 Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,057,525,200.00
122111	1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,057,525,200.00
12213	1.1.1.04.3.01.03 Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,371,372.00
122131	1.1.1.04.3.01.03.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	100,000.00
122134	1.1.1.04.3.01.03.3 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,000,000.00
122135	1.1.1.04.3.01.03.4 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,271,372.00
13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,172,777,271.00	-
1311	1.1.1.05.2 Нэмэлт санхүүжилтийн орлого	195,628,871.00	-
131101	1.1.1.05.2.01 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000,000.00	-
131104	1.1.1.05.2.03 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,100,100.00	-
131105	1.1.1.05.2.04 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,528,771.00	-
1320	1.1.1.05.3 Орон нутгийн төсвөөс санхүүжих	977,148,400.00	-
132001	1.1.1.05.3.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	977,148,400.00	-
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,167,674,355.42	1,356,572,292.85
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,167,674,355.42	1,356,572,292.85
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,055,058,663.55	1,336,654,304.44
2101	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	636,960,904.26	775,124,844.20
210101	1.1.2.01.1.01.01 Үндсэн цалин	356,666,838.20	413,605,215.48
210102	1.1.2.01.1.01.02 Нэмэгдэл	217,676,165.57	330,780,868.74
210103	1.1.2.01.1.01.03 Унаа хоолны хөнгөлөлт	835,000.00	-
210104	1.1.2.01.1.01.04 Урамшуулал	27,708,211.00	2,221,856.00
210105	1.1.2.01.1.01.05 Гэрээт ажлын хөлс	34,074,689.49	28,516,903.98
2102	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,508,178.21	96,275,781.99
210201	1.1.2.01.1.02.01 Тэтгэврийн даатгалын зардал	53,911,653.53	63,873,463.99
210202	1.1.2.01.1.02.02 Тэтгэмжийн даатгалын зардал	6,303,849.60	7,526,000.00
210203	1.1.2.01.1.02.03 ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,153,246.03	4,266,900.00

210204	1.1.2.01.1.02.04 Ажилгүйдлийн даатгалын зардал	3,004,678.20	3,887,718.00
210205	1.1.2.01.1.02.05 Эрүүл мэндийн даатгалын зардал	12,134,750.85	16,721,700.00
2103	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,558,586.86	83,870,299.88
210301	1.1.2.01.1.03.01 Гэрэл, цахилгаан	9,366,386.86	11,675,080.40
210302	1.1.2.01.1.03.02 Түлш, халаалт	51,192,200.00	72,195,219.48
2104	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	44,426,660.00	33,314,353.00
210401	1.1.2.01.1.04.01 Бичиг хэрэг	2,810,600.00	3,737,400.00
210402	1.1.2.01.1.04.02 Тээвэр, шатахуун	35,707,030.00	22,891,828.00
210403	1.1.2.01.1.04.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	953,400.00	1,352,700.00
210405	1.1.2.01.1.04.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,212,830.00	4,871,625.00
210406	1.1.2.01.1.04.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,742,800.00	460,800.00
2106	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	8,096,500.00	31,095,427.11
210603	1.1.2.01.1.06.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	743,600.00
210604	1.1.2.01.1.06.04 Урсгал засвар	8,096,500.00	30,351,827.11
2107	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	11,254,000.00	7,145,000.00
210702	1.1.2.01.1.07.02 Дотоод албан томилолт	11,254,000.00	7,145,000.00
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,285,204.00	1,074,091.00
210801	1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,012,000.00	209,600.00
210802	1.1.2.01.1.08.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210804	1.1.2.01.1.08.04 Тээврийн хэрэгслийн татвар	409,204.00	251,308.00
210805	1.1.2.01.1.08.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	99,000.00
210807	1.1.2.01.1.08.07 Газрын төлбөр	576,000.00	514,183.00
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	212,968,630.22	308,754,507.26
210901	1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	71,592,160.00	136,789,243.50
210902	1.1.2.01.1.09.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,465,000.00	1,120,000.00
210903	1.1.2.01.1.09.03 Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,911,470.22	170,845,263.76
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,615,691.87	19,917,988.41
2131	1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	16,578,188.41
21311	1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	16,578,188.41
213112	1.1.2.01.4.01.01.2 Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	16,578,188.41
2131121	1.1.2.01.4.01.01.2.1 Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	16,578,188.41
2132	1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	45,502,000.00	3,339,800.00
213208	1.1.2.01.4.02.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,502,000.00	-
213209	1.1.2.01.4.02.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	3,339,800.00
2134	1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	67,113,691.87	-
213403	1.1.2.01.4.04.03 Төвлөрүүлэх шилжүүлэг	48,165,443.87	-
213405	1.1.2.01.4.04.05 Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	18,948,248.00	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	499,706,627.58	312,607,729.65
V	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	639,341.86
225005	1.2.2.04 Үнэ төлбөргүй гарсан зардал	-	639,341.86
VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(639,341.86)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	499,706,627.58	311,968,387.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,185,475,260.00	1,074,364,921.00
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,697,989.00	1,074,364,921.00
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	12,697,989.00	12,468,349.00
120004	1.1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	12,697,989.00	12,468,349.00
1200041	1.1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,697,989.00	12,468,349.00
122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,061,896,572.00
1221	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	1,061,896,572.00
12211	1.1.1.1.04.3.01.01 Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,057,525,200.00
122111	1.1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,057,525,200.00
12213	1.1.1.1.04.3.01.03 Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,371,372.00
122131	1.1.1.1.04.3.01.03.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	100,000.00
122134	1.1.1.1.04.3.01.03.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,000,000.00
122135	1.1.1.1.04.3.01.03.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,271,372.00
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,172,777,271.00	-
1311	1.1.1.1.05.2 Нэмэлт санхүүжилтийн орлого	195,628,871.00	-
131101	1.1.1.1.05.2.01 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000,000.00	-
131104	1.1.1.1.05.2.04 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,100,100.00	-
131105	1.1.1.1.05.2.05 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,528,771.00	-
1320	1.1.1.1.05.3 Орон нутгийн төсвөөс санхүүжих	977,148,400.00	-
132001	1.1.1.1.05.3.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	977,148,400.00	-
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,032,290,260.00	1,055,866,501.00
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,032,290,260.00	1,055,866,501.00
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,674,568.13	1,035,948,512.59
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	635,102,704.26	773,501,499.88
210101	1.1.1.2.01.1.01.01 Үндсэн цалин	355,449,490.20	411,981,871.16
210102	1.1.1.2.01.1.01.02 Нэмэгдэл	217,676,165.57	330,780,868.74
210103	1.1.1.2.01.1.01.03 Унаа хоолны хөнгөлөлт	835,000.00	-
210104	1.1.1.2.01.1.01.04 Урамшуулал	27,708,211.00	2,221,856.00
210105	1.1.1.2.01.1.01.05 Гэрээт ажлын хөлс	33,433,837.49	28,516,903.98
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,668,943.01	96,727,667.00
210201	1.1.1.2.01.1.02.01 Тэтгэврийн даатгалын зардал	54,072,418.33	64,325,167.00
210202	1.1.1.2.01.1.02.02 Тэтгэмжийн даатгалын зардал	6,303,849.60	7,526,000.00
210203	1.1.1.2.01.1.02.03 ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,153,246.03	4,266,900.00
210204	1.1.1.2.01.1.02.04 Ажилгүйдлийн даатгалын зардал	3,004,678.20	3,887,900.00
210205	1.1.1.2.01.1.02.05 Эрүүл мэндийн даатгалын зардал	12,134,750.85	16,721,700.00
2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,558,586.86	65,179,077.60
210301	1.1.1.2.01.1.03.01 Гэрэл, цахилгаан	9,366,386.86	11,986,878.60
210302	1.1.1.2.01.1.03.02 Түлш, халаалт	51,192,200.00	53,192,199.00
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	41,574,170.00	28,883,030.00

210401	1.1.1.2.01.1.04.01 Бичиг хэрэг	2,639,300.00	2,435,800.00
210402	1.1.1.2.01.1.04.02 Тээвэр, шатахуун	27,059,240.00	18,987,505.00
210403	1.1.1.2.01.1.04.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	953,400.00	1,352,700.00
210405	1.1.1.2.01.1.04.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,212,830.00	5,145,225.00
210406	1.1.1.2.01.1.04.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,709,400.00	961,800.00
2106	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	14,043,300.00	31,405,417.11
210601	1.1.1.2.01.1.06.01 Багаж, техник, хэрэгсэл	1,326,000.00	-
210603	1.1.1.2.01.1.06.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	616,000.00	743,600.00
210604	1.1.1.2.01.1.06.04 Урсгал засвар	12,101,300.00	30,661,817.11
2107	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	11,214,000.00	5,660,000.00
210702	1.1.1.2.01.1.07.02 Дотоод албан томилолт	11,214,000.00	5,660,000.00
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,531,804.00	1,074,091.00
210801	1.1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,258,600.00	226,420.00
210802	1.1.1.2.01.1.08.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210804	1.1.1.2.01.1.08.04 Тээврийн хэрэгслийн татвар	409,204.00	251,308.00
210805	1.1.1.2.01.1.08.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	99,000.00
210806	1.1.1.2.01.1.08.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
210807	1.1.1.2.01.1.08.07 Газрын төлбөр	576,000.00	497,363.00
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	75,981,060.00	33,517,730.00
210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	70,381,060.00	32,070,730.00
210902	1.1.1.2.01.1.09.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,600,000.00	1,447,000.00
213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,615,691.87	19,917,988.41
2131	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	16,578,188.41
21311	1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	16,578,188.41
213112	1.1.1.2.01.4.01.01.2 Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	16,578,188.41
2131121	1.1.1.2.01.4.01.01.2.1 Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\)	-	16,578,188.41
2132	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	45,502,000.00	3,339,800.00
213208	1.1.1.2.01.4.02.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,502,000.00	-
213209	1.1.1.2.01.4.02.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	3,339,800.00
2134	1.1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	67,113,691.87	-
213403	1.1.1.2.01.4.04.03 Төвлөрүүлэх шилжүүлэг	48,165,443.87	-
213405	1.1.1.2.01.4.04.05 Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	18,948,248.00	-
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	153,185,000.00	18,498,420.00
V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	153,185,000.00	18,498,420.00
22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	153,185,000.00	18,498,420.00
2200	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	153,185,000.00	18,498,420.00
225106	1.1.2.2.01.1.06 Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	153,185,000.00	18,498,420.00
VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(153,185,000.00)	(18,498,420.00)
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,695,910,734.51		2,256,935,693.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	187,561,302.77		187,561,302.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	1,883,472,037.28	-	2,444,496,995.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	499,706,627.58		499,706,627.58
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	2,383,178,664.86	-	2,944,203,623.40
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	2,383,178,664.86	-	2,944,203,623.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	47,512,544.21		47,512,544.21
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,458,213.17	130,566,745.37	2,430,691,209.07	-	2,991,716,167.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(47,537,294.21)	-		(47,537,294.21)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	311,968,387.79		311,968,387.79
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,458,213.17	83,029,451.16	2,742,659,596.86	-	3,256,147,261.19

5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,076,521,300.00	1,053,415,260.59	23,106,039.41	97.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,076,521,300.00	1,053,415,260.59	23,106,039.41	97.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,021,300.00	1,051,915,460.59	22,105,839.41	97.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	772,987,000.00	772,986,999.89	0.11	100.0%

210101	Үндсэн цалин	727,695,800.00	411,467,371.17	316,228,428.83	56.5%
210102	Нэмэгдэл		330,780,868.74	(330,780,868.74)	
210104	Урамшуулал	-	2,221,856.00	(2,221,856.00)	
210105	Гэрээт ажлын хөлс	45,291,200.00	28,516,903.98	16,774,296.02	63.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,668,500.00	96,668,500.00	-	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	64,266,000.00	64,266,000.00	-	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	7,526,000.00	7,526,000.00	-	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,266,900.00	4,266,900.00	-	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,887,900.00	3,887,900.00	-	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	16,721,700.00	16,721,700.00	-	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,331,300.00	65,179,077.60	5,152,222.40	92.7%
210301	Гэрэл, цахилгаан	26,697,300.00	11,986,878.60	14,710,421.40	44.9%
210302	Түлш, халаалт	43,634,000.00	53,192,199.00	(9,558,199.00)	121.9%
2104	Хангамж, бараа материалын зардал	30,639,800.00	26,925,225.00	3,714,575.00	87.9%
210401	Бичиг хэрэг	3,031,900.00	2,435,700.00	596,200.00	80.3%
210402	Тээвэр, шатахуун	17,986,500.00	17,029,800.00	956,700.00	94.7%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,886,100.00	1,352,700.00	533,400.00	71.7%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,400,000.00	5,145,225.00	254,775.00	95.3%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,335,300.00	961,800.00	1,373,500.00	41.2%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,210,200.00	43,954,837.10	255,362.90	99.4%
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,500,000.00	8,500,000.00	-	100.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	998,200.00	743,600.00	254,600.00	74.5%
210604	Урсгал засвар	34,712,000.00	34,711,237.10	762.90	100.0%
2107	Томилолт, зочны зардал	5,741,000.00	5,660,000.00	81,000.00	98.6%
210702	Дотоод албан томилолт	5,741,000.00	5,660,000.00	81,000.00	98.6%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,597,400.00	4,074,091.00	1,523,309.00	72.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	539,200.00	226,420.00	312,780.00	42.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	-	403,200.00	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-	300,000.00	0.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,000.00	251,308.00	3,692.00	98.6%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	165,000.00	99,000.00	66,000.00	60.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,209,000.00	3,000,000.00	209,000.00	93.5%
210807	Газрын төлбөр	726,000.00	497,363.00	228,637.00	68.5%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,846,100.00	36,466,730.00	11,379,370.00	76.2%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,600,700.00	35,019,730.00	9,580,970.00	78.5%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,245,400.00	1,447,000.00	1,798,400.00	44.6%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.00	1,499,800.00	1,000,200.00	60.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	1,499,800.00	1,000,200.00	60.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	1,499,800.00	1,000,200.00	60.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,076,521,300.00	1,069,993,449.00	6,527,851.00	99.4%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,065,521,300.00	1,057,525,100.00	7,996,200.00	99.2%

132001	Орон нутгийн төсвөөс	1,065,521,300.00	1,057,525,100.00	7,996,200.00	99.2%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,000,000.00	12,468,349.00	(1,468,349.00)	113.3%
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,000,000.00	12,468,349.00	(1,468,349.00)	113.3%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	24.00	2.00	92.3%
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	3.00	2.00	1.00	66.7%
620004	Гэрээт ажилтан	7.00	6.00	1.00	85.7%

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,371,372.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,371,372.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,531,372.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,500.00
210101	Үндсэн цалин	514,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,167.00
210201	Тэтгэврийн даатгал	59,167.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,957,705.00
210402	Тээвэр, шатахуун	1,957,705.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,840,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,840,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,840,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,371,372.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,371,372.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,535,472.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	835,900.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:


- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ



илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 317,661.8 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	160.7	577.4	416.7
Бараа материал	172,614.9	143,263.2	(29,351.7)
Үндсэн хөрөнгө	2,773,286.2	3,119,883.0	346,596.8
Нийт хөрөнгө	2,946,061.8	3,263,723.6	317,661.8
Өглөг	1,858.2	10,738.3	8,880.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,944,203.6	3,252,985.3	308,781.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,946,061.8	3,263,723.6	317,661.8

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 577.4 мянган төгрөг болж 416.7 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 143,263.2 мянган төгрөг болж 29,351.7 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 3,119,883.0 мянган төгрөг болж 346,596.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 15,498.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 302,769.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 171,007.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 112,474.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 28,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуульд балансаас үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,738.3 мянга болж 8,880.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүжилт дутуу олгосноос 4,507.9 мянган төгрөгийн мал тооллого, тээвэр шатахуун, томилолтын өглөг үүссэн байна.

Мөн тайланд онд шүүхийн шийдвэрээр тогтоосон 2023 оны халаалтын төлбөрийн алданги 6,230.4 мянган төгрөгөөр өглөг үүссэнтэй холбоотойгоор өр төлбөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,252,985.3 мянган төгрөг болж 308,781.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлан үеийн үр дүнгээс шалтгаалжээ.



3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 942,539.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 12,500.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 955,039.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 102,132.5 мянган төгрөгөөр өсгөн 1,057,171.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 19,349.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,076,521.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10,76,521.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,057,526.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 12,468.3 мянга, нийт 1,069,993.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тайлант оны батлагдсан төсвөөс 6,527.9 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,053,415.3 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байна. Тайлант онд батлагдсан төсвөөс 6,527.9 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт авч, 16,578.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	712,863.90	707,667.50	5,196.4	99.3%
2	Баг хорооны ҮА-ны зардал/80106/	167,962.60	167,947.80	14.8	100.0%
3	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	78,082.80	72,931.10	5,151.7	93.4%
4	Нийтлэг үйлчилгээ /80112/	63,124.30	63,124.30	0.0	100.0%
5	Мэдээлэл сурталчилгааны зардал /80205/	933.1	80.0	853.1	8.6%
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/	2,500.00	1,499.80	1,000.2	60.0%
7	Орон нутгийн нөөц хөрөнгө /81102/	16,000.20	15,931.30	68.9	99.6%
8	Мал тооллого /81507/	1300	0	1,300.0	0.0%
9	Улсын баяр наадам /82801/	5,000.00	5,000.00	0.0	100.0%
10	Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх /81701/	21,500.40	13,288.30	8,212.1	61.8%
11	Ахмадын сан /81549/	800	800	0.0	100.0%
12	Хур хог хаягдал, хортон шавж устгах	6,454.00	5,145.20	1,308.8	79.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

1. Программ хангамжийн судалгаа

/мянган төгрөгөөр/					
Д/Д	Программ, лиценз нийлүүлсэн байгууллагын нэр	Санхүүгийн тайланд бүртгэлтэй эсэх /тийм, үгүй/	Зориулалт	Тайланд онд гэрээний дагуу төлсөн төлбөр	Ашиглагдахгүй байгаа программ хангамжийн тайлбар
1	Сум хөгжүүлэх сангийн программ	тийм	Зээлийн мэдээлэл	150.0	
2	Acoelous программ	тийм	Бүртгэл санхүү		Шинээр онлайн программ нэвтэрсэн.
3	Бичиг хэргийн программ	тийм	Архив бичиг хэрэг		Ер систем шинэчлэгдсэн тул давхар бүртгэх шаардлагагүй болсон.
4	Нэгтгэлийн программ	тийм	Санхүүгийн тайлан		Э-Тайлангаар нэгтгэл шивдэг болсон.
5	CTS-Санхүүгийн онлайн программ	үгүй	Бүртгэл санхүү		
6	Няравын онлайн программ	үгүй	Санхүүгийн анхан шатны бүртгэл		
Нийт дүн				150.0	

2. Унаа, хоол, сургалт семинарын орон тооны судалгаа

/мянган төгрөг/					
№	Үзүүлэлт	Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Унаа, хоолны зардал	13,500.0	13,500.0	318.0	Сумын ЗДТГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/22 тушаалын дагуу хоолны зардлыг 2500 төгрөгөөр тооцоон олгож эхэлсэн.
2	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	5,710.0	5,660.0	50.0	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусадсаны дагуу багшийн хөгжлийн зардлаас багш нарыг 3 удаагийн сургалтад хамруулсан байна.
3	Гадаад томилолт, арга хэмжээ	0.00	0.00	0.00	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
4	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.00	0.00	0.00	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
5	Орон тоо	26	24	0.00	Мэдээлэл технологийн ажилтан, ЗДТГ-ын манаач гэсэн 2 орон тоогоор буурсан байна.
6	Хэвлэл мэдээлэл	0.00	0.00	0.00	Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,535.5 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 835.9 мянга, нийт 4,371.4 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 514.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 59.2 мянга, хангамжийн материалын зардалд 1,957.7 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,840.0 мянга төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар нь 2025 онд шууд худалдан авалтаар 12,476.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2,623.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,846.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 7,372.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 29,894.6 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг тус тус шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.



Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,167,674.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 11,676.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,341.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,339,228.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,392.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 10,713.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлэн ажиллахад алдаа, зөрчил илэрсэнгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 169, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ.

Зүүнхангай сумын Засаг даргын Тамгын газар нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны онцлог, салбарын стандартууд болон хууль, эрх зүйн шаардлагуудад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллахгүй байгаа нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байсанд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.



4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 86,922.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	86,922.8	2	86,922.8	100%
Нийт дүн	2	86,922.8	2	86,922.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоог аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар баталсан ч сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар тамгын газрын бүтэц, орон тоо, цалин нэмэгдлийг батлахдаа батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй сантехникч засварчин, 4 багийн төвийн сахиулыг гэрээтээр цалинжуулан ажиллаж байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 207,793.2 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 207,793.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 69 дүгээр тогтоолын дагуу үнэ төлбөргүй шилжин ирсэн 200,000.0 мянган төгрөгийн өртөгтэй “Увс 100” цогцолбор хөшөөг бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул орлогод авч бүртгэлд тусгуулан залруулга хийлгэлээ.
2. Тамгын газрын бараа материалын тайлангийн мал амьтад дансанд бүртгэлтэй Герефорд үүлдрийн 3,846.0 мянган төгрөгийн 1 бухан бяруу, Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлсэн 3,947.2 мянган төгрөгийн 1 бухын бярууны нас дэвшилт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 5.1.5 дэх заалтад “Хэмжигдэхүйц байх”, 14.4.7 дахь заалтад Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул нас дэвшилт хийж залруулга хийлгэлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой

1.1. Илрүүлэлт:

Зүүнхангай сумын Засаг даргын Тамгын газар нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.



1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны онцлог, салбарын стандартууд болон хууль, эрх зүйн шаардлагуудад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө орлогод аваагүй	1	200,000.0	1	200,000.0			1	200,000.0				
Нас дэвшилт хийгээгүй	1	7,763.2			1	7,763.2	1	7,763.2				
Дүн	2	207,793.2	1	200,000.0	1	7,763.2	2	207,793.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл


/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж ажиллах	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0
Нийт дүн	1	0.0					1	0.0



Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНТ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Р.АЮУШ/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

